



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2015 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 435

Улаанбаатар хот

“АА Аперейзал” ХХК-д даатгалын хохирол  
үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай  
зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.3, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5.1.2, 11.1, 11.4, Хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 2.39 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “АА Аперейзал” ХХК-д даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай.

2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “АА Аперейзал” ХХК /Б.Номун/-нд үүрэг болгосугай.

3. Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, Хорооны нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Бүртгэл, зөвшөөрлийн газар /Э.Мөнхбаяр/-т, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалагсугай.

ДЭД ДАРГА

Э.БАТБОЛД

